ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

**TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA**
**REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION**

2026 оны 09 сарын 24 өдөр Дугаар 69 Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, "Худалдаа, хөгжлийн банк" ХК (цаашид "Банк" гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны холбогдох этгээд болох "Ти Ди Би Капитал" ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн дагуу "Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ"-г байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцлийн бусад нөхцөлийг тодорхойлж, гарын үсэг зурах холбогдох бусад баримт бичигт Банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох гүйлгээг хийх болон газар эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбоотой шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** **РАНДОЛФ КОППА**